



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БУА-2024/05/НА-СТА-ТШЗ

|                                                                                            |                                                                                                                                         |
|--------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Цахим хуудас:<br><a href="http://www.audit.mn">www.audit.mn</a><br>Булган аймаг<br>2023 он | Дарга,<br>тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ<br>Утас: 70342580      Цахим хаяг: <a href="mailto:erdeneb@audit.gov.mn">erdeneb@audit.gov.mn</a> |
|                                                                                            | Аудитын менежер: Ж.Энхцоодол<br>Утас: 70342716      Цахим хаяг: <a href="mailto:enhtsoodolj@audit.gov.mn">enhtsoodolj@audit.gov.mn</a>  |
|                                                                                            | Аудитор: А.Сувдаа<br>Утас: 70342495      Цахим хаяг: <a href="mailto:suvdaaa@audit.gov.mn">suvdaaa@audit.gov.mn</a>                     |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**БУЛГАН АЙМГИЙН  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082  
Утас/Факс: 7034-2580  
E-mail: bulgan@audit.gov.mn

2024.02.22 № 58

танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН  
ДАРГА Н.БАТЖАРГАЛ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Байгууллагын тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

**Аудитын гол асуудал**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээнд 871 иргэн харуулж 11.4 сая төгрөг, ажилд зуулчлах үйлчилгээнд 499 иргэн хамруулж 8.2 сая төгрөг, Хөдөлмөрт бэлтгэх сургалтад 406 иргэнийг хамруулж 40.2 сая төгрөг, аж ахуй эрхлэлтийг дэмжих

006020125

санхүүгийн дэмжлэгээр 152 иргэнд 864.6 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 96 иргэн хамруулж 204.3 сая төгрөг, түр ажлын байрыг дэмжих арга хэмжээнд 635 иргэн хамруулж 206.7 сая төгрөг, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд 68.1 сая төгрөгийг тус зарцуулжээ.

### **Бусад мэдээлэл**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан 1 хөтөлбөр 7 зориулалт арга хэмжээний хүрээнд 1,604.9 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж 1,403.5 сая төгрөгийг зарцуулж 210.4 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

## Хоёр. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

/төгрөгөөр/

|                                                | Үзүүлэлт                                          | 2022.12.31             | 2023.12.31.            |
|------------------------------------------------|---------------------------------------------------|------------------------|------------------------|
| <b>Санхүүгийн байдлын тайлан</b>               |                                                   |                        |                        |
|                                                | Эргэлтийн хөрөнгийн дүн                           | 238,947,930.0          | 238,947,930.0          |
|                                                | Эргэлтийн бус хөрөнгийн дүн                       | 2,185,700,407.0        | 1,776,002,023.4        |
|                                                | <b>Нийт хөрөнгийн дүн</b>                         | <b>2,254,830,111.7</b> | <b>1,831,626,854.9</b> |
|                                                | Нийт өр төлбөрийн дүн                             | -                      | -                      |
|                                                | Цэвэр хөрөнгө/өмчийн дүн                          | 2,254,830,111.7        | 1,831,626,854.9        |
|                                                | <b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>        | <b>2,254,830,111.7</b> | <b>1,831,626,854.9</b> |
| <b>Санхүүгийн үр дүнгийн тайлан</b>            |                                                   |                        |                        |
|                                                | Үйл ажиллагааны орлогын дүн                       | 1,556,114,200.0        | 1,615,544,500.0        |
|                                                | Үйл ажиллагааны зардлын дүн                       | 1,106,011,469.0        | 1,100,775,536.0        |
|                                                | <b>Үйл ажиллагааны үр дүн</b>                     | <b>450,102,731.0</b>   | <b>514,768,964.0</b>   |
|                                                | Үйл ажиллагааны бус үр дүн                        | -                      | -                      |
|                                                | <b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>                | <b>450,102,731.0</b>   | <b>514,768,964.0</b>   |
| <b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</b> |                                                   |                        |                        |
|                                                | Дахин илэрхийлсэн үлдэгдэл                        | 1,626,163,722.9        | 1,616,236,500.9        |
|                                                | Тайлант оны үр дүн                                | -                      | 514,768,964.0          |
|                                                | <b>Эцсийн үлдэгдэл</b>                            | <b>1,626,163,722.9</b> | <b>2,131,005,464.9</b> |
| <b>Мөнгөн гүйлгээний тайлан</b>                |                                                   |                        |                        |
|                                                | Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн                | 1,556,114,200.0        | 1,616,975,000.0        |
|                                                | Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн               | 2,013,000,389.0        | 2,229,096,942.0        |
|                                                | <b>Үйл ажиллагааны ЦМГ</b>                        | <b>(456,886,189.0)</b> | <b>(612,121,942.0)</b> |
|                                                | <b>Хөрөнгө оруулалтын ЦМГ</b>                     | <b>-</b>               | <b>-</b>               |
|                                                | <b>Санхүүгийн ажиллагааны ЦМГ</b>                 | <b>456,897,889.0</b>   | <b>611,848,942.0</b>   |
|                                                | <b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>                  | <b>11,700.0</b>        | <b>(273,000.0)</b>     |
|                                                | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл  | 456,897,889.0          | 611,848,942.0          |
|                                                | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | -                      | -                      |
| <b>Төсвийн гүйцэтгэлийн тайлан</b>             |                                                   |                        |                        |
|                                                | <b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>          | <b>-</b>               | <b>1,403,493,394.0</b> |
|                                                | Урсгал зардал                                     | -                      | 1,403,493,394.0        |
|                                                | Хөрөнгийн зардал                                  | -                      | -                      |
|                                                | <b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>             | <b>-</b>               | <b>1,335,959,572.0</b> |
|                                                | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал          | -                      | 1,335,959,572.0        |
|                                                | Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас             | -                      | -                      |

### Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 92,402.7 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 92,402.7 мянган төгрөгийн алдааг залрууллаа.

Үүнд: Бараа материалын 4,317.7 мянган төгрөгийн орлогын гүйлгээг алдаатай бүртгэсэн, ХБИ-ний 88,000.0 мянган төгрөгийн авлагын бүртгэлийг төсөлд хамрагдагч бүрээр бус нийт дүнгээр бүртгэсэн, гэрээний дагуу 3 хувийн урамшууллын шатахууны орлогыг үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор тайлагнаагүй нь НББ-ын тухай хуулийн 6.1, НБББББ-ын 5-ын А-д, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар журмын 4.21-ийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

### Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

#### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт алдаа |      | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан |     | Буруу тусган илэрхийлсэн |      | Үүнээс     |      |              |     | Зөвлөмж |     |
|------------------|------------|------|-----------------------------------|-----|--------------------------|------|------------|------|--------------|-----|---------|-----|
|                  |            |      |                                   |     |                          |      | Залруулсан |      | Залруулаагүй |     |         |     |
|                  | Тоо        | Дүн  | Тоо                               | Дүн | Тоо                      | Дүн  | Тоо        | Дүн  | Тоо          | Дүн | Тоо     | Дүн |
| ХЭДС             | 2          | 92.3 | 0.0                               | -   | 2                        | 92.3 | 2          | 92.3 | 0.0          | 0.0 | 0.0     | 0.0 |
| Дүн              | 2          | 92.3 | 0.0                               | -   | 2                        | 92.3 | 2          | 92.3 | 0.0          | 0.0 | 0.0     | 0.0 |

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт зөрчил |     | Үүнээс        |     |                 |     |         |     |                                      |                     |                                                 |     |
|------------------|-------------|-----|---------------|-----|-----------------|-----|---------|-----|--------------------------------------|---------------------|-------------------------------------------------|-----|
|                  |             |     | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |     | Зөвлөмж |     | Хариуцлага тооцуулах албан шаардлага |                     | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |     |
|                  | Тоо         | Дүн | Тоо           | Дүн | Тоо             | Дүн | Тоо     | Дүн | Тоо                                  | Албан тушаалтны тоо | Тоо                                             | Дүн |
| ХЭДС             | 0           | 0   | 0             | -   | 0               | 0   | 0       | 0   | 0                                    | -                   | 0                                               | -   |
| Дүн              | 0           | 0   | 0             | -   | 0               | 0   | 0       | 0   | 0                                    | -                   | 0                                               | -   |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр                      | Нийт зөрчил |       | Үүнээс        |     |                 |       |         |     |     |      |
|----------------------------------------------------------|-------------|-------|---------------|-----|-----------------|-------|---------|-----|-----|------|
|                                                          |             |       | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |       | Зөвлөмж |     |     |      |
|                                                          | Тоо         | Дүн   | Тоо           | Дүн | Тоо             | Дүн   | Тоо     | Дүн | Тоо | Дүн  |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил |             |       |               |     |                 |       |         |     |     |      |
| ХЭДС                                                     | 1           | 534.3 |               |     | 1               | 534.3 |         |     |     |      |
| Дүн                                                      | 1           | 534.3 |               |     | 1               | 534.3 |         |     |     |      |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил                 |             |       |               |     |                 |       |         |     |     |      |
| Дүн                                                      | 0           | -     | 0             | -   | 0               | -     | 0       | -   | 0   | -    |
| Нийт дүн                                                 | 1           | 56.0  | 0             | -   | 0               | -     | 0       | -   | 1   | 56.0 |

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо |                             |                    |                 | Санал дүгнэлтийн хэлбэр |                |       |                            |
|---|-----------------------------|--------------------------|-----------------------------|--------------------|-----------------|-------------------------|----------------|-------|----------------------------|
|   |                             | Аудитад хамрагдах        | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр |                    |                 |                         |                |       |                            |
|   |                             |                          | Санал дүгнэлт гаргасан      | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Зөрчилгүй               | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| A | 1                           | 2                        | 3                           | 4                  | 5               | 7                       | 8              | 9     | 10                         |
| 1 | ТШЗ                         | 1                        | 1                           |                    |                 | 1                       |                |       |                            |
|   | НИЙТ                        | 1                        | 1                           |                    |                 | 1                       |                |       |                            |